



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/10/НА-СА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580	Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Булган аймаг 2023 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716	Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn
	Аудитор: А.Сувдаа Утас: 70342495	Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.03.25 № 345

танай _____ ны № _____ т

БУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА П.НӨХӨРЛӨЛБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Булган сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгч байна. Үүнд:

- ОНХС-аас санхүүжсэн хөрөнгийг бүртгэл тайланд дутуу тусгасан,
- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрдэл дутуу,
- Дотоод хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар “Цоожэд” ББН, “Эмийн цэцэглэн” ББН өрхийн эрүүл мэндийн төвүүд татгалзсан дүгнэлт авсан зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.4.5, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 54 дүгээр зүйлийн 54.4.5, УСНББОУС 1, 17-той нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус

006020799

байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны XII/01 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын XII/01 дүгээр тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 21.9 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 8 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 6,210.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 6,113.2 сая төгрөгийг зарцуулж 96.9 сая төгрөгийг дутуу зарцуулжээ.

Сумын ИТХ-ын XIX/08 дугаар тогтоолоор сумын Засаг даргын “Ирээдүйд тэмүүлсэн хот” хөтөлбөрийн хэрэгжилтийг тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,901,817.2	2,762,257.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	559,366.6	1,383,936.5
33	АВЛАГА	1,120,941.2	1,167,521.9
35	БАРАА МАТЕРИАЛ	221,509.4	210,799.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,395,261.0	14,505,510.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,395,261.0	14,505,510.3
39200	Биет хөрөнгө	9,914,491.7	12,252,116.1
39300	Биет бус хөрөнгө	1,480,769.3	2,253,394.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,297,078.2	17,267,767.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,831.3	14,829.7
41300	Өглөг	8,831.3	14,829.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,288,246.9	17,252,938.1
51	Засгийн газрын хувь оролцоо	13,288,246.9	17,252,938.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	5,815,760.9	5,815,760.9
51200	Хуримтлагдсан үр дүн	6,765,323.4	10,730,014.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	707,162.7	707,162.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,297,078.2	17,267,767.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,501,959.2	15,584,518.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4,035,368.3	5,781,125.3
110	Орлогын албан татвар	3,591,316.1	5,271,993.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,591,316.1	5,271,993.1
113	Хөрөнгийн албан татвар	229,397.0	267,222.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	214,655.2	241,909.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,484,493.2	4,427,399.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,483,497.8	4,427,399.3
122	Тусламжийн орлого	995.3	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,982,097.7	5,375,993.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,047,316.9	11,203,417.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,047,316.9	11,203,417.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,579,445.6	5,311,747.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,323,049.8	1,613,231.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,051.1	186,014.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,001,820.5	238,078.8
2104	Хангамж, бараа материалын зардал	95,407.5	85,374.2
2105	Нормативт зардал	197,938.1	123,119.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	136,330.9	155,750.1
2107	Томилолт, зочны зардал	10,739.2	14,414.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,354,637.9	1,800,923.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,298,470.6	1,094,840.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,467,871.4	5,891,670.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(545,357.8)	4,381,100.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,560,174.3	416,109.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(18,105,532.0)	3,964,991.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,471.6	-	31,471.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(77.2)	-	(77.2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	31,394.4	-	31,394.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(0.6)	-	(0.6)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	(18,105.5)	-	(18,105.5)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,288.2	-	13,288.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,288.2	-	13,288.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(0.6)	-	(0.6)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,287.6	-	13,287.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.3	-	0.3
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	3,965.0	-	3,965.0
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	17,252.9	-	17,252.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,887,480.4	13,976,836.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	4,035,368.3	5,781,125.3
110	Орлогын албан татвар	3,591,316.1	5,271,993.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,591,316.1	5,271,993.1
113	Хөрөнгийн албан татвар	229,397.0	267,222.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	214,655.2	241,909.7
1181	Газрын төлбөр	21,411.5	25,520.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	413.4	6,175.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	683,454.7	790,860.2
120	Нийтлэг татварын бус орлого	682,747.7	790,860.2
122	Тусламжийн орлого	707.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,168,657.4	7,404,850.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,825,351.6	12,275,936.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,825,351.6	12,275,936.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,354,485.0	6,366,840.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,319,689.6	1,611,886.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	160,493.3	181,435.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,005,345.5	238,078.8
2104	Хангамж, бараа материалын зардал	78,107.5	80,589.4
2105	Нормативт зардал	157,267.8	33,587.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	143,340.1	149,389.5
2107	Томиллолт, зочны зардал	10,739.2	14,099.8

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,282,764.1	1,773,596.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196,737.8	2,284,177.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,470,866.6	5,909,095.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,062,128.9	1,700,899.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	492,467.2	576,077.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	492,467.2	576,077.7
2200	Дотоод эх үүсвэрээр	492,467.2	576,077.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(492,467.2)	(576,077.7)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(321,294.8)	(300,252.2)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	321,294.8	299,952.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	300.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	248,366.9	824,569.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	310,999.7	559,366.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	559,366.6	1,383,936.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,210,116.50	6,113,196.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,464,741.90	5,394,899.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,181,489.00	5,112,187.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,155,578.20	1,140,008.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,447.30	126,394.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,122,593.20	2,095,947.52
2104	Хангамж, бараа материалын зардал	51,050.00	50,902.24
2105	Нормативт зардал	5,800.00	5,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	264,864.80	264,503.34
2107	Томилолт, зочны зардал	7,450.00	6,287.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,216,532.90	1,213,756.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	213,172.60	208,588.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	283,252.90	282,712.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	247,752.90	247,752.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,500.00	34,959.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	445,374.60	418,344.43
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	300,000.00	299,952.21
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,210,116.50	6,165,977.06
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,659,655.60	5,781,522.30
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	550,460.90	384,454.77
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	82,128.23
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	134,908.91
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	129	129
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	63	63
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	63	63

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	723,844.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	721,584.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	710,561.1
2104	Хангамж, бараа материалын зардал	6,127.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,330.0
2107	Томилолт, зочны зардал	864.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	632,443.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,796.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,023.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,750.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,273.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,260.1
2200	Дотоод эх үүсвэрээр	2,260.1
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	723,844.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	723,844.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Булган сумын ЗДТГ нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, ОНХС-гийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх, зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль Нийгмийн даатгалын тухай хууль Татварын тухай хууль Төрийн албаны тухай хууль Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын 2023 оны санхүүгийн тайлан дахь Тайлант онд баталсан татварын болон татварын бус орлогыг мөнгөн сууриар хөтөлж, ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын 2023оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,970.7 төгрөгөөр буюу 29.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	559.37	1,383.94	824.57
Авлага	1,120.94	1,167.52	46.58
Бараа материал	221.51	210.80	(10.71)
Үндсэн хөрөнгө	11,395.26	14,505.51	3,110.25
Нийт хөрөнгө	13,297.08	17,267.77	3,970.69
Өр төлбөр	8.83	14.83	6.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	13,288.25	17,252.94	3,964.69
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,297.08	17,267.77	3,970.69

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмч данснууд байна.

- ОНЕО давж биелснээс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 147 хувиар өссөн,
- ОНХС, аймгийн авто замын сан, ОНХО болон төсвийн хөрөнгөөр нийт 3,237.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаанд тусгагдсан e.gov.mn-д бүртгэгдсэн шийдвэртэй газрыг суурь үнэлгээгээр тооцон 766.8 сая төгрөгийн газрыг орлого авснаас нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,383.9 сая төгрөг болж, өмнөх оноос 824.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	559.37	1,383.94	824.57
Төгрөг	559.37	1,383.94	824.57
Төрийн сангийн харилцах	555.92	1,371.00	815.08
Арилжааны банк дахь харилцах	3.45	12.93	9.49
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	559.37	1,383.94	824.57

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

“Эмийн цэцэглэн” ББН ӨЭМТ-өөс бусад байгууллага болон ОНЕО, ОНХС, ХХС, “Цоожэд” ББН ӨЭМТ, ЖДҮДС-ийн үлдэгдэл өмнөх оноос өссөн байна. Тайлант онд цалингийн нэмэгдэлтэй холбоотойгоор татварын орлого давж биелж ОНЕО-ын үлдэгдэл өмнөх оноос 161 хувь буюу 762.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 147 хувиар өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,167.5 сая төгрөг болж, өмнөх оноос 46.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.07	1.07	1.01
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Дансны авлага /ТӨҮГ/	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	-	-
Байгууллагаас авах авлага	116.83	156.20	39.38
Хувь хүмүүсээс авах авлага	1,004.05	1,010.24	6.20
Дүн	1,120.94	1,167.52	46.58

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Тайлант онд ӨЭМТ-үүдийн санхүүжилт дутуу орсноос 29.8 сая төгрөг, СДОА-ын талбай тусгаарлалтын авлага 19.4 сая төгрөг, ОНХС-аас урьдчилан шилжүүлсэн 7.0 сая төгрөг, ХХС-гийн зээлийн үлдэгдэл 1,010.2 сая төгрөг авлагын үлдэгдэл нь өмнөх оноос 4.0 хувиар өссөн байна.

Аудитын илрүүлэлт

- Талбай тусгаарлалтын гэрээний дагуу СДОА 14.7 сая төгрөг, ТҮА 0.1 сая төгрөг, ОНХС 7.0 сая төгрөгийн авлагыг хүлээн зөвшөөрч бүртгээгүйг аудитын хугацаанд залрууллаа.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 210.8 сая төгрөг болж, өмнөх оноос 10.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт(-)
Түүхий эд материал	62.10	41.70	(20.40)
Тусгай зориулалттай материал	46.88	42.99	(3.89)
Эм боох материал	-	-	-
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	5.32	8.30	2.98
Хангамжийн материал	65.29	81.28	15.99
Бичиг хэргийн материал	14.62	11.91	(2.71)
Аж ахуйн материал	0.35	3.87	3.52
Сэлбэг хэрэгсэл	5.32	5.75	0.42
Түлш, шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал	21.65	15.02	(6.63)
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	-	-	-
Мал амьтад	-	-	-
Дүн	221.51	210.80	(10.71)

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Өмнөх онтой харьцуулахад ӨЭМТ-үүд болон ТҮА-ын бараа материалын үлдэгдэл 13-43 хувиар буюу нийт 52.5 сая төгрөгөөр буурч, ЗДТГ, ИТХ, СДОА 50-73 хувиар буюу 41.8 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа материалыг орлого авахдаа СДОА 1.8 сая төгрөг, ТҮА 3.0 сая төгрөг, СО 1.6 сая төгрөгийг алдаатай бүртгэсэн

- ТТЗ-ийн тайланд бараа материалыг 0.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын хугацаанд залрууллаа.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	0	0	0
Дүн	0	0	0

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,161.8 сая төгрөг болж, өмнөх оноос 489.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	3,686.50	3,467.16	(219.34)
Авто-тээврийн хэрэгсэл	426.90	558.94	132.04
Машин тоног төхөөрөмж(компьютер)	831.07	758.64	(72.42)
Тавилга, аж ахуйн эд хогшил	81.23	251.52	170.29
Зам гүүр байгууламж	2,127.59	2,086.35	(41.24)
Түүх соёлын дурсгалт зүйл	771.35	771.35	-
Бусад үндсэн хөрөнгө	1,989.85	4,358.15	2,368.30
Дуусаагүй барилга, байгууламж	3.02	2.87	(0.15)
Биет бус хөрөнгө	1,989.85	4,358.15	2,368.30
Программ хангамж	3.02	2.87	(0.15)
Бусад биет бус хөрөнгө	1,477.75	2,250.52	772.77
Дүн	11,395.26	14,505.51	3,110.25

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

“Эмийн цэцэглэн ББН ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд ашигладаг автомашиныг сумын ЗДТГ-т шилжүүлэх шийдвэр гарсны дагуу шилжүүлжээ. ЗДТГ, ТҮА ОНХС, ОНХО, АЗС-гийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө болон ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаанд тусгагдсан egazar.gov.mn-д бүртгэгдсэн шийдвэртэй газрыг суурь үнэлгээгээр тооцон газрыг орлого авснаар өмнөх оноос 3,110.3 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг цэвэр дүнгээр өсгөсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- ГХБХБГ-аас ирүүлсэн egazar.gov.mn-д бүртгэлтэй газрыг тайлан бүртгэлд тусгаагүйг ЗДТГ 309.7 сая төгрөг, ТҮА 457.1 сая төгрөгийн газрыг тайланд тусгуулж залрууллаа.
- ОНХС-аас санхүүжсэн 19.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14.4.5, 16.5.2-д заасныг хэрэгжүүлээгүй, иж бүрэн байх батламж мэдээдлийн хангаагүй тул таслан зогсоох албан шаардлага өгөх /ТТЗ/

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 14.8 сая төгрөг болж, өмнөх оноос 6.0 сая төгрөгөөр буюу 67.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Өр төлбөр

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат үнэт цаас	-	-	-
Богино хугацаат зээлийн өглөг	-	-	-
Өглөг	8.83	14.83	6.00
Ажилчидтай холбогдсон өглөг	0.10	0.54	0.44
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	-	(0.00)
Бусад өглөг	8.73	14.28	5.56
Байгууллагад төлөх өглөг	8.02	7.64	(0.37)
Хувь хүмүүст төлөх өглөг	0.03	1.47	1.43
Урьдчилж орсон орлого	-	-	-
Дүн	8.83	14.83	6.00

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

“Эмийн цэцэглэн” ББН ӨЭМТ 5.2 сая төгрөг, ТҮА 1.2 сая төгрөг, ЖДҮДС 0.2 сая төгрөгөөр өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь өмнөх оноос 67.9 хувиар өсгөжээ.

3.4.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 17,252.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3,964.7 сая төгрөгөөр буюу 29.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,815.76	5,815.76	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	6,765.32	10,730.01	3,964.69
Өмнөх үеийн үр дүн	24,870.86	6,765.02	(18,105.83)
Тайлант үеийн үр дүн	(18,105.53)	3,964.99	22,070.52
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	707.16	707.16	-
Дүн	13,288.25	17,252.94	3,964.69

Эх сурвалж: Булган сумын 2023 оны нэгтгэсэн тайлангаас

Засгийн газрын хувь оролцоо өмнөх оны үлдэгдлээс 29.8 хувиар өссөн нь дээр дурдсан хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны XIII/14 тоот тогтоолоор сумын 2023 оны төсвийг 4,665.8 сая төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 4,206.7 сая төгрөгөөр, аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 353.2 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 181.7 сая төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлэг 282.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 48.0 сая төгрөг, СХС-ийн урьд оны үлдэгдлээс 5.0 сая төгрөг, үндсэн болон хүүгийн орлогоос 295.0 сая төгрөг орохоор баталсныг тайланд онд 2 удаа тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 23-ны XV/11 тоот тогтоолоор сумын 2023 оны төсвийг 574.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 5,240.6 сая төгрөгөөр баталж татварын болон татварын бус орлогыг 4,545.8 сая төгрөгөөр, аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 162.4 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 226.7 сая төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлэг 282.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 48.0 сая төгрөг, СХС-ийн урьд оны үлдэгдлээс 18.0 сая төгрөг,

үндсэн болон хүүгийн орлогоос 282.0 сая төгрөг орохоор тодотгосныг ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 18-ны XVII/03 тоот тогтоолоор сумын 2023 оны төсвийг 1,217.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 6,457.9 сая төгрөгөөр баталж сумын татварын болон татварын бус орлогыг 5,339.1 сая төгрөгөөр, аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 247.8 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 219.7 сая төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлэг 359.3 сая төгрөг, өвс тэжээлийн орлого 10.0 сая төгрөг, СХС-ийн үндсэн болон хүүгийн орлогоос 282.0 төгрөгөөр өөрчлөн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр татварын 5,781.1 сая төгрөг, татварын бус орлого 404.4 сая төгрөг, аймаг төвлөрүүлэх санхүүгийн дэмжлэг 247.8.0 сая төгрөг, эхний үлдэгдлээс 474.1 сая төгрөг, ОНХС-аас 358.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,113.2 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 96.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	348.2	322.7	25.5	92.7%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	3066.7	3042.9	23.8	99.2%
3	Орон нутгийн зорилтот Хөрөнгө оруулалт	407.4	380.9	26.5	93.5%
4	Соёл урлаг	98.7	98.1	0.7	99.3%
5	Сургуулийн өмнөх боловсрол	544.3	533.2	11.1	98.0%
6	Ерөнхий боловсрол	1412.7	1407.6	5.1	99.6%
7	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	247.8	247.8	0.0	100.0%
8	Ойжуулалт	84.4	80.2	4.2	95.0%
	Нийт	6210.1	6113.2	96.9	98.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Нэг албан хаагчид 0.9 сая төгрөгийн цалин илүү тооцож олгосон /ЗДТГ/,
- Төрийн үйлчилгээний албан хаагчийг үнэлж олгох үр дүнгийн урамшууллын журам батлаагүй /ЗДТГ, ТҮГ/,
- Байгууллагын аварга ажилтан 2022 оны 5, 2023 оны 6 албан хаагчид цалингийн сангаас нэг сарын үндсэн цалингаар нийт 10.2 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан /ЗДТГ/,
- ЗД-ын нөөц хөрөнгөнөөс захирамжгүйгээр 3.0 сая төгрөг зарцуулсан /ЗДТГ/,
- Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхдээ Засаг даргын зөвлөлийн хурлын хурлаар хэлэлцүүлээгүй 29.6 сая төгрөг зарцуулсан /ЗДТГ/,
- Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд ойн Бургасны плантаци байгуулах, ойн үрийн талбайн арчилгааны ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлээгүй /СДОА/,
- Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд ойн Бургасны плантаци байгуулах, ойн үрийн талбайн арчилгааны ажлаас хөрөнгө бэлтгэсэн /СДОА/,
- Түр томилогдсон хуулийн ажилтан ажлаас чөлөөлөгдөхөд амралт тооцож олгоогүй бөгөөд эрх зүйн үндэслэлгүйгээр нэг сарын үндсэн цалин олгосон /ИТХ/,
- Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 115 дугаар тогтоолыг үндэслэн нягтлан бодогч, нярав, үйлчлэгчид нийт 6,500.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон /ИТХ/,
- 6-р багийн гэрэлтүүлэг болон коридор засварын ажлыг гүйцэтгэгч байгууллагаат техник хяналтын зардлыг шилжүүлсэн /ИТХ/,

- 6-р багийн гэрэлтүүлгийг гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгүүлэхдээ үйл ажиллагааны чиглэлд багтаагүй, тусгай зөвшөөрөлгүй ААНБ-аар гүйцэтгүүлсэн /ИТХ/,
- 2-р багийн гэрэлтүүлэг төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн /ОНХС/,
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэргүүлээгүй буюу хоршоо хөгжүүлэх сангаас санхүүжих арга хэмжээг нийт дүнгээр батлуулсан /ХХС/,
- Томилолтын анхан шатны баримтгүй зарцуулсан /ХХС, “Эмийн цэцэглэн” ББН ӨЭМТ/,
- Өмнөх оны хүүгийн орлогоос журамд заасан хувиас үйл ажиллагаа болон урамшуулалд илүү буюу зориулалт бус зарцуулсан /ХХС/,
- Дотоод хяналт шалгалтыг 6 чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөгөө батлуулж ажилласан ч үр дүн хангалтгүй /ТТЗ/,
- ТШЗ-д санхүүгийн тайланг нэгтгүүлэхдээ алдаа зөрчилгүй, үнэн зөв нэгтгүүлээгүй /ТТЗ/,
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй, Сангийн сайдын тушаалыг зөрчиж төгрөгөөр тайлагнасан /ТТЗ/

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 227.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/125 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,845.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 109.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Сумын ИТХ-ын тогтоолын нэгдүгээр хавсралтаар сумын хүрэх үр дүн болон ОНХС-гийн төлөвлөгөөг шилэн дансны нэгтгэсэн системд мэдээлээгүй, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож

мэдээлсэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасныг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2.Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг байршуулаагүй дүнгээс хамаарч СДОА 56.0 сая төгрөгийн 1 зөвлөмж, ХХС, ОНХС нийт 1,539.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, ЗДТГ, ИТХ, ТҮА зөрчлийг давтан гаргасан тул дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох албан шаардлага өгч ажиллалаа.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлангийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхдээ Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэлгүй 29.8 сая төгрөгийг зарцуулсанд холбогдох байгууллагад албан шаардлага хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр 01/667 тоотор ирүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.5	1	0.5	100
Албан шаардлага	1	0	1	0	100
Зөвлөмж	2	0	2	0	100
Нийт дүн	4	0.5	4	0.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын ИТХ-ын бүтэц орон тоог Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолын 2-ыг хэрэгжүүлэн ажиллаж буй эсэхийг хянах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,177.1 сая төгрөгийн алдаа илэрснийг залруулж, 21.7 сая төгрөгийн 6 зөрчил¹ илэрснээс, 19.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 4,728.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 799.4 сая төгрөгийн 10 алдааг залруулж, 6.1 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 19.0 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 86.1 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн байна.

5.2 Албан шаардлага

1. ОНХС-гаас санхүүжсэн 19.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага өгөх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТҮА-ын өмнөх аудитаар өгсөн актыг барагдуулаагүй, бардуулах ажлыг зохион байгуулаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 23.1, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөрийн актыг барагдуулах ажлыг зохион байгуулах

2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй, Сангийн сайдын тушаалыг зөрчиж төгрөгөөр тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 54.5, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 54.5, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын дагуу иж бүрэн тайланг Төрийн аудитын газарт ирүүлж хэвших

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналт шалгалтыг 6 чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөгөө батлуулж ажилласан ч үр дүн хангалтгүй байгаа нь ЗГ-ын 2011 оны 311 тогтоолын, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Журмын дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцох

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТШЗ-ын санхүүгийн тайланг нэгтгэхдээ алдаатай, үнэн зөв нэгтгээгүй нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: санхүүгийн тайланг хянаж санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэх Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	310.5	2	310.5	0	0	2	310.5	0	0	0	0
ИТХ	1	5.1	1	5.1			1	5.1				
ТҮА	4	460.3	2	457.1	2	3.2	4	460.3	0	0	0	0
СДОА	2	16.4	0	0	2	16.4	2	16.4	0	0	0	0
ОНХС	1	7.0	1	7.0			1	7.0				
ТТЗ	12	2177.1	8	56.5	4	2120.6	12	2177.1				
Дүн	22	2976.4	14	836.2	8	2140.2	22	2976.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ	4	67.4	0	0	1	10.2	3	57.2	0	0	0	0
ИТХ	2	26.5			1	6.5	1	20				
ТҮА	3	12.7	0	0	2	2.7	1	10	0	0	0	0
СДОА	2	30.8	0	0	1	2.3	1	28.5	0	0	0	0
ОНХС	2	0.9			1	0.9	1	0				
ХХС	3	24.7			1	0	2	24.7				
"Эмийн цэцэглэн" ББН ӨЭМТ	2	2.4	1	0.4					1	2		
"Цоожэд" ББН ӨЭМТ	2	1.1	1	0.1					1	1		
ТТЗ	6	21.7	0		1	19	5	2.7				
Дүн	26	188.2	2	0.5	8	41.6	14	143.1	2	3	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	2	1772.6			2	1772.6		
ИТХ	1	262.4			1	262.4		
ТҮА	2	417.2			2	417.2		
СДОА	1	56					1	56
ОНХС	1	874.2			1	874.2		
ХХС	1	665.3			1	665.3		
ТТЗ	1	0					1	0
Дүн	9	4047.7	0	0	7	3991.7	2	56
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	29.6	0		1	29.6	0	
Дүн	1	29.6	0	0	1	29.6	0	0
Нийт дүн	6	1,597.10	0	0	4	1,575.10	2	22

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	8	5	3		1	2		2
2	Төсөл, хөтөлбөр	0							
3	ЗГТС	0							
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ	0							
	НИЙТ	9	6	3	0	1	3	0	2